



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/263

Ховд

Ажлын хэсэг байгуулж, захиалагчийн  
хяналт хийлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Жаргалант сумын нийтийн байрнуудад хэрэглээний халуун ус өгөх ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Р.Янжмаа

- Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Г.Гончигсүрэн

- Захирагчийн ажлын албаны дарга

С.Өнөржаргал

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Б.Отгонбаяр

- Бадамлах дөл ХХК-ний ерөнхий инженер

Б.Бямбажав

- Бадамлах дөл ХХК-ний инженер

Д.Сүх-Эрдэнэ

- "Ховд дулааны станц" Төрийн өмчит хувьцаат компанийн шугамын инженер

М.Мөнхцэцэг

- Жаргалант багийн Засаг дарга

Б.Сумхүү

- Магсаржав багийн Засаг дарга

И.Цэрмаа

- Наран багийн Засаг дарга

Г.Цэлмэг

- Рашаант багийн Засаг дарга

Б.Сайнзаяа

- Цамбагарав багийн Засаг дарга

Б.Байгальмаа - Буянт багийн Засаг дарга  
Б.Түмэндэлгэр - Бугат багийн Засаг дарга  
Г.Насанжаргал - Баатархайрхан багийн Засаг дарга

Нарийн бичгийн  
дарга Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

2. “Ховд дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани, Бадамлах дөл ХХК-ний гүйцэтгэж буй Нийтийн байрнуудад хэрэглээний халуун ус өгөх ажлын гүйцэтгэлд иргэд, сууц өмчлөгчийн холбоо, багийн Засаг дарга нартай хамтран хяналт тавьж, сар бүрийн 25-ны дотор тайлагнаж, илэрсэн зөрчлийг тухай бүрт арилгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН